



Ерөнхийлөгч Томас С.Монсон

Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг

Үнэний тухай мэдлэг болон амьдралын хамгийн чухал асуудлуудын хариулт нь Бурханы тушаалуудад дуулгавартай байснаар л бидэнд ирдэг.

Хайрт ах, эгч нар аа, би энэ өглөө та нартай хамт байгаадаа ямар их баяртай байна вэ. Та бүхэнд хандан ярихдаа би та нараасаа итгэл мөн залбирлыг хүсч байна.

Олон зууны турш эрэгтэй, эмэгтэй хүмүүс, мөнх бус амьдрал болох энэ амьдрал дахь өөрсдийн байр суурь болон зорилгоо, мөн амар амгалан болон аз жаргалд хэрхэн хүрч болохыг мэдэж, ойлгохыг оролдсоор ирсэн юм. Бид бүгд л үүнийг эрж хайдаг.

Энэ мэдлэг болон ойлголт нь бүх хүн төрөлхтөнд нээлттэй байна. Эдгээр нь мөнхийн үнэнд оршдог. Сургаал ба Гэрээний 1-р хэсгийн 39-р шүлэгт: “Учрыг болгоогтун, мөн харатгун, Их Эзэн бол Бурхан мөн, бас Сүнс гэрчилдэг, мөн тэрхүү гэрчлэл үнэн болой, бас тэрхүү үнэн үүрд мөн үргэлж оршино” гэсэн байдаг.

Мөн нэгэн яруу найрагч:

*Тэнгэр нурж,
дэлхий үгүй болох цагт*

*Тэсэн үлдэх нь ҮНЭН юм,
Мөнхийн, өөрчлөгдөшгүй,
үргэлжид байх тэр л ҮНЭН
гэж бичжээ.¹*

“Тийм үнэн хаана байна? Бид яаж тэр үнэнийг таних вэ?” гэж зарим хүмүүс асуух байх л даа. 1833 оны тавдугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгсөн илчлэлтэд Их Эзэний тунхагласан байдаг:

“Мөн үнэн бол байгаа юмсын, байсан зүйлүүдийн, мөн ирэх зүйлүүдийн тухай мэдлэг юм . . .

“Үнэний Сүнс бол Бурханых юм. . . .

“Мөн түүний зарлигуудыг сахиhaас бусдаар хүмүүн бүрэн байдлыг хүлээн авах нь үгүй.

“[Бурханы] зарлигуудыг сахидаг тэрээр, үнэнд алдаршиж мөн бүх зүйлийг мэдэх хүртлээ үнэн ба гэрлийг хүлээж авдаг болой.”²

Энэ ямар гайхалтай амлалт вэ!

Сайн мэдээний бүрэн байдал сэргээгдсэн энэхүү мэдээллийн эрин

үед бид үнэнийг олохын тулд танигдаагүй зам, мэдэхгүй газраар явах шаардлагагүй юм. Хайрт Тэнгэрлэг Эцэг маань бидний явах замыг тодорхойлж, үргэлж зөвийг заах удирдамж—*дуулгавартай байдлын зарчмыг өгсөн билээ*. Үнэний тухай мэдлэг болон амьдралын хамгийн төвөгтэй асуултуудын хариулт нь Бурханы тушаалуудад дуулгавартай байснаар л бидэнд ирдэг.

Бид амьдралынхаа турш дуулгавартай байдалд суралцдаг. Балчир байхаас минь л биднийг аюулаас хол байлгахын тулд асран халамжлагч нар маань бидэнд заавар болон дүрмүүдийг тогтоож өгдөг. Эдгээр дүрмийг нь яг таг дагавал бидний амьдрал хавьгүй хялбар байх боломжтой юм. Харамсалтай нь бидний олонх нь дуулгавартай байдлын чухлыг алдаа гаргасныхаа дараа л олж мэддэг.

Намайг бага байхад гэрийнхэн маань зун болгон, долоон сарын эхнээс есөн сарын эхэн хүртэл, Ютагийн Прово Хавцалын Вивиан Парк дахь байшиндаа зусдаг байж билээ.

Бодох санах зүйлгүй, цагийг хамтдаа өнгөрөөдөг байсан сайн найзуудын маань нэгийг Данни Ларсен гэдэг байсан ба тэднийх ч мөн адил Вивиан Паркт байшинтай байсан юм. Өдөр бүр бид хоёр, хөвгүүдийн хувьд диваажин болох тэр газруудаар хэрэн хэсч, гол горхиноос загас барьж, чулуу болон элдэв янзын зүйлс цуглуулж, уул хадаар мацан, цаг мөч бүрийг сайхан өнгөрөөдөг байж билээ.

Нэгэн өглөө Данни бид хоёр ярилцан, орой нь түүдэг асааж

зуслангийн бүх найзуудаа урихаар шийдлээ. Тэгээд бидэнд хажуухандаа байсан хөндийд хүүхдүүд цуглаж болох газрыг цэвэрлэх шаардлага гарсан юм. Харин тэр талбай дахь 6-р сарын хуурай хатсан өвс л биднийг санасан зүйлээ хийхэд маань саад болж байв. Хангалттай томоохон газрыг чөлөөлөхийн тулд бид өндөр ургасан өвсийг зулгааж эхэллээ. Хамаг чадлаараа угзарч, татаж байсан ч бид хоёр тэр зөрүүд зэрлэг ургамлаас атгын чинээг л зулгаан авч байсан юм. Энэ чигээрээ үргэлжилбэл тэр талбайг цэвэрлэхэд бүтэн өдөр шаардагдах бөгөөд бид хоёр ядарч мөн цуцаж эхлээд байлаа.

Гэтэл 8 настай миний ухаанд гэнэт нэгэн сайхан санаа орж ирэв. Би Даннид хандан: “Энэ зэрлэг ургамлыг ерөөсөө шатаачихъя. Яг тэр дугараг газрын өвсийг л *шатаачихъя!*” гэж хэллээ. Тэр ч дуртайяа зөвшөөрөхөд би шүдэнз авахаар гэр рүүгээ гүйв.

Наймхан настай балчир бидэнд шүдэнз ашиглахыг зөвшөөрсөн байж гэж бүү бодоцгоогоорой. Данни бид хоёрт том хүнгүйгээр шүдэнз ашиглахыг хатуу хориглосон байсан юм гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Галын аюулын талаар Данни бид хоёрт зөндөө анхааруулж байсан. Гэсэн ч шүдэнз хаана байгааг би мэдэж байсан бөгөөд бид тэр талбайг зайлшгүй цэвэрлэх шаардлагатай байв. Ямар ч эргэлзээгүйгээр би гэр рүүгээ гүйн ороод хэдэн шүдэнзний модыг хэнд ч харагдалгүйгээр халаасандаа нуун авч гарлаа.

Асуудлаа шийдэх зүйл маань халаасанд буй болохоор би Данни руу эргэн их л баяртай гүйж билээ. Бидний тавьсан гал хэрэгтэй газрыг маань цэвэрлэхийн тулд л илбийн юм шиг өөрөө унтарчих байх гэж бодож байснаа би санадаг юм.

Шүдэнзээ чулуунд зурж асаагаад хатсан хуурай өвсөнд аваачиж тавилаа. Бензин асгачихсан юм шиг тэр дороо л гал дүрэлзэн асав. Зэрлэг ургамал шатаж алга болж байхыг хараад Данни бид

хоёр эхэндээ их л баяссан, гэвч тэр гал өөрөө унтрах ямар ч шинжгүй ассаар байлаа. Бид яагаад ч тэргалыг унтрааж чадахгүйгээ мэдээд сандарч эхлэв. Дүрэлзэн шатах гал уулын хормойг даган цаашилж юу юугүй хуш моддыг болон замдаа дайралдсан бүхнийг устгах аюул нүүрлэлээ.

Эцэст нь бид яалт ч үгүй тусламж хүсэхээс өөр аргагүй болсон юм. Тун удалгүй Вивиан Паркт байсан бүх л эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийлэн, усанд норгосон шуудайгаар галыг цохиж түймрийг унтраахын тулд нааш цааш гүйлдэж эхлэв. Нилээн хэдэн цагийн дараа сүүлийн ноцож буй цогийг унтраасан юм. Ингэж өндөр настай хуш моднууд болон түймэрт автах байсан гэр орноо авч үлдсэн билээ.

Тэр өдөр Данни бид хоёр хэцүүхэн боловч чухал хэдэн зүйлсийг сурсны нэг нь дуулгавартай байхын ач холбогдол байсан юм.

Бидний бие махбодын аюулгүй байдлыг баталгаажуулж байдаг хууль, дүрэм журмууд байдаг. Үүнтэй адил бидний сүнсэлэг байдлыг хамгаалах заавар болон тушаалуудыг Их Эзэн бэлдэж өгсөн бөгөөд эдгээр нь бидэнд энэхүү хувирамтгай, мөнх бус оршихуйд төөрчилгүй Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очих боломжийг олгодог юм.

Амьтан золих заншилдаа баригдсан тэр үеийнхэнд хандан Самуел хэдэн зуун жилийн тэртээ: “Дуулгавартай дагах нь тахил өргөхөөс илүү, сонсож дагах нь хуцын өөхнөөс илүү”³ гэж зоригтойгоор тунхаглаж байжээ.

Энэ эринд Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитэд хандан Тэрээр “зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг шаарддаг бөгөөд мөн эрмэлзэгчид хийгээд дуулгавартнууд эдгээр эцсийн өдрүүдэд Сионы нутгийн сайн сайхныг зооглох болно”⁴ хэмээн хэлж байжээ.

Бүх бошиглогчид, хуучны эсвэл одоогийнх ялгаагүй, бидний авралд дуулгавартай байдал нь зайлшгүй хэрэгтэй гэдгийг мэдсээр ирсэн.

Нифай “би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” хэмээн тунхаглаж байсан.⁵ Зарим нэгэн нь итгэл болон дуулгавартай байдлаа алдан бүдэрч байхад, Их Эзэний хүссэн зүйлсийг биелүүлээгүй тохиолдол Нифайд нэгээхэн ч байгаагүй юм. Үүний ачаар тоолж баршгүй олон үеийнхэн адислагдсан билээ.

Дуулгавартай байдлын сэтгэл хөдөлгөм жишээнүүдийн нэг нь Абрахам, Исаак хоёрын түүх юм. Бурханы хэлсний дагуу хайрт Исаакаа золиос болгохоор Мориагийн нутагт аваачих нь Абрахамд хичнээн хэцүү байсан бол. Товлосон газартаа очихоор явж байхад нь Абрахамын зүрх хэрхэн өвдөн тарчилж байсныг бид ойлгож чадна гэж үү? Тэрээр Исаакаа хүлэн, өргөлийн тавцан дээр тавьж, амийг нь авахаар хутга далайсан тэр мөчид түүний бие махбод болон оюун санаа нь маш ихээр зовон шаналж байсан нь гарцаагүй юм. Тэрээр Их Эзэндээ огт эргэлзэлгүй итгэн, Түүнд бүрэн найдаж Түүний тушаалыг дагасан юм. “Хөвгүүнд гар бүү хүр! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ”⁶ гэж хэлэх үгс нь ямар гайхалтай мөн яасан их хүсэн хүлээж байсан үгс байсан болоо.

Абрахамыг туршиж мөн сорьсны эцэст түүний итгэл болон дуулгавартай байдлын хариу болгон Их Эзэн түүнд: “чи Миний үгийг дуулгавартай дагасан учир газар дэлхийн бүх үндэстэн чиний үрсээр дамжуулан ерөөгдөх болно”⁷ гэсэн гайхалтай амлалтыг өгдөг.

Хэдийгээр бидний дуулгавартай байдлыг тийм айхтар, зүрх шимшрүүлэм аргаар сорихгүй ч гэсэн, бид бүгд дуулгавартай байх ёстой билээ.

1873 оны 10-р сард Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит “Дуулгавартай байдал нь тэнгэрийн хамгийн дээд хууль юм”⁸ хэмээн тунхагласан байдаг.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли “Хожмын Үеийн Гэгээнтнүүд,

Бурханы. . . хэлснийг дуулгавартай даган амьдарснаар аз жаргал, амар амгалан, хөгжил дэвшил, амжилт бүтээл болон мөнхийн амь мөн авралыг хүлээн авдаг”⁹ хэмээн хэлсэн.

Дуулгавартай байдал нь бошиглогч нарын шинж чанар юм; олон зууны турш энэ нь тэдэнд хүч чадал болон мэдлэгийг олоход тусалсаар ирсэн. Бид ч мөн адил энэхүү хүч чадал болон мэдлэгийн эх сурвалжийг авах эрхтэй гэдгээ ухаарах нь маш чухал юм. Бурханы тушаалуудыг дуулгавартай дагах л юм бол бид үүнийг одоо ч гэсэн авч болно.

Олон жилийн турш онцгой итгэл мөн дуулгавартай, тоолж баршгүй олон хүнтэй би уулзаж байсан. Тэд намайг адислаж мөн урамшуулсан юм. Ийм хоёр хүний талаар та бүхэнтэй хуваалцахыг минь зөвшөөрнө үү.

Волтер Крауз Сүмийн итгэлтэй гишүүн байсан бөгөөд дэлхийн хоёрдугаар дайны дараа Зүүн Герман гэж нэрлэгдсэн газар гэр бүлийн хамт амьдарч байсан юм. Эрх чөлөөг нь хязгаарласан энэ цаг үед дэлхийн тэр хэсэгт их зовлон бэрхшээлийн дунд байсан хэдий ч Крауз ах Их Эзэнд хайртай мөн түүнд үйлчилдэг нэгэн байсан юм. Тэрээр түүнд өгсөн даалгавар болгоныг итгэлтэйгээр мөн чин сэтгэлээсээ биелүүлдэг байж.

Нөгөө нь, Германд байхдаа сүмд хөрвөгдөж, тэндээ 1911 онд 17 настайдаа баптисм хүртсэн Унгар гаралтай Иоханн Денндорфер гэдэг хүн юм. Тэрээр баптисм хүртсэнээсээ хойш тун удалгүй Унгар руу буцсан аж. Дэлхийн хоёрдугаар дайны дараа тэрээр өөрийн төрөлх нутагтаа, Дебрецен гэдэг хотод яг л шоронд байгаа юм шиг амьдрахад хүрчээ. Унгарын ард түмэн ч мөн эрх чөлөөгөө алдаад байсан юм.

Волтер Крауз ах Денндорфер ахыг таньдаггүй байсан хэдий ч түүний гэрийн багшаар томилогдож, түүн дээр байнга очиж байх даалгавар хүлээн авчээ. Крауз ах гэрийн багшийн хамтрагч руугаа утсаар залгаж, “Бидэнд Иоханн

Денндорфер ахынд очих даалгавар өгсөн. Энэ долоо хоногт түүн дээр очиж сайн мэдээ хуваалцахаар та надтай хамт явж чадах уу?” гэж асуужээ. Тэгснээ үргэлжлүүлэн: “Денндорфер ах Унгарт амьдардаг” гэж нэмж хэлэв.

Гайхширсан хамтрагч нь түүнээс: “Хэзээ явах вэ?” гэж асууж гэнэ.

“Маргааш” гэж Крауз ах хариулав.

“Бид хэзээ буцаж ирэх вэ?” гэж хамтрагч нь асуулаа.

Крауз ах “Өө, долоо хоног болох байлгүй дээ, гэхдээ бид *буцаж* ирж чадвал шүү дээ” гэж гэнэ.

Тэгээд тэр хоёр ах Германы зүүн хойд хэсгээс Унгарын Дебрецен хот руу вагон, автобусаар яван Денндорфер ахынд очих урт аяндаа гарчээ. Дайн эхэлснээс хойш Денндорфер ахынд гэрийн багш нар ирээгүй байж. Тэрээр Их Эзэний хоёр үйлчлэгчийг хараад, түүнийг зорин ирсэнд нь маш ихээр баярлажээ. Эхлээд тэр тэдэнтэй гар барьж мэндэлсэнгүй. Харин тэр унтлагынхаа өрөөнд орж шүүгээнээсээ олон жил хуримтлагдсан аравны нэгийн өргөлөө хийсэн хайрцаг авчирчээ. Тэрээр тэр хайрцага гэрийн багш нартаа өгөөд: “Одоо би Их Эзэнд өргүй боллоо. Одоо л би Их Эзэний үйлчлэгч нартай гар барин мэндлэх эрхтэй боллоо” гэж хэлжээ. Тэрхүү итгэл дүүрэн ах олон жилийн турш сүмээсээ тасарсан байсан хэдий ч өөрийн олсон шалихгүй бага орлогоосоо арван хувийг дуулгавартайгаар мөн тогтмол цааш хийж байсан нь түүний сэтгэлийг хичнээн их хөдөлгөсөн талаар Крауз ах хожим надад ярьж билээ. Тэрээр хэзээ төлөх эсвэл төлөх боломж түүнд олдох эсэхийг мэдэлгүйгээр хадгалж байсан аж.

Волтер Крауз ах есөн жилийн өмнө 94 настайдаа нас нөгчсөн юм. Тэрээр амьдралынхаа турш итгэл болон дуулгавартайгаар үйлчилж, надад болон түүнийг мэддэг байсан бусад олон хүнд урам зориг өгч байсансан. Тэрээр ганц ч асуулт

асуулгүй, нэг ч гомдлын үг унагалгүй, мөн ямар ч шалтаг тоочилгүй авсан даалгавруудаа биелүүлдэг байсан билээ.

Ах эгч нар аа, дуулгавартай байдал нь энэ амьдралын хамгийн агуу шалгуур юм шүү. “Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно”¹⁰ хэмээн Их Эзэн хэлсэн байдаг.

Аврагч “Учир нь миний гараас адислалыг хүлээн авахыг хүсэх тэд бүтд тэрхүү адислалын тулд өгөгдсөн хуулийг, мөн үүний нөхцлүүдийг, дэлхийн суурингаас өмнө үндэслэгдэн бий болсноор нь баримтлах ёстой”¹¹ хэмээн тунхагласан.

Аврагчийн үзүүлсэн дуулгавартай байдлын жишээнээс илүү гарах өөр жишээ байхгүй. Түүний талаар Паул:

“Тэр Хүү нь байсан хэрнээ зовлон шаналаас дуулгавартай байдалд суралцсан;

“Тэр төгс болгогдсоноороо Өөрт нь дуулгавартай байдаг бүх хүнд мөнх авралын эх үндэс нь болсон”¹² гэж хэлсэн байдаг.

Төгс амьдралаар амьдарч, Өөрийн ариун үүрэг зорилгодоо хүндэтгэлтэй ханддаг байснаар Аврагч маань Бурханы жинхэнэ хайрыг харуулсан юм. Тэр ямар ч үед их зан гаргаагүй. Тэр хэзээ ч бардамнан онгирч байгаагүй. Тэр хэзээ ч урвагч болоогүй. Тэр ямагт төлөв даруу байсан. Тэр аливаад чин сэтгэлээсээ ханддаг байсан. Тэр байнга дуулгавартай байсан билээ.

Тэрбээр худал хуурмагийн эзэн, бүр тэр чөтгөрөөр уруу татагдсан ч, Тэрбээр 40 өдөр, 40 шөнө мацаг барьсны эцэст өлссөн ч, бас хилэнцэт нэгэн хамгийн ихээр уруу татагч саналыг Есүст тавьсан ч, зөв гэдгийг нь Өөрөө мэдэж байсан зүйлээс гажуулах гэсэн оролдлогыг няцааснаар дуулгавартай байдлын бурханлиг үлгэр дуурайллыг харуулсан билээ.¹³

Тэрээр Гетсеманид амь тэмцэн зовж, “хөлс нь хөлс нь цусны дусал

мэт газарт дуслан”¹⁴ шаналах үедээ “Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол, энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч Миний хүсэл бус харин Таны хүсэл биелэгдэг” гэж хэлэн дуулгавартай Хүүгийн үлгэр жишээг харуулсан юм.¹⁵

Эртний төлөөлөгч нартаа хэлж байсан “Чи Намайг дага” хэмээх үгсээ тэрээр надад мөн танд ч адил хэлж байна. Дуулгавартай дагах хүсэл бидэнд байдаг уу?¹⁶

Хайж буй мэдлэгээ, хүлээж буй хариултаа болон энэхүү төвөгтэй, хувирамтгай дэлхийн бэрхшээлүүдийг даван туулахад туслах хүч чадлыг бид Их Эзэний тушаалуудыг дуулгавартай дагаснаар л олж авч чадна. Их Эзэний үгсийг би дахин нэг иш татъя. Тэрээр: “[Бурханы] зарлигуудыг сахидаг тэрээр, үнэнд тэрээр алдаршиж мөн бүх зүйлийг мэдэх хүртлээ үнэн ба гэрлийг хүлээж авдаг болой”¹⁷ гэж хэлсэн билээ.

Бид дуулгавартай хүмүүст гарцаагүй ирэх баялаг адислалуудыг аваасай хэмээн би даруухнаар залбирч байна. Бидний Эээн, Аврагч Есүс Христийн нэрээр, амен.

ТЭМДЭГ ЛЭЛҮҮД

1. “Oh Say, What Is Truth?” *Hymns*, no. 272.
2. Сургаал ба Гэрээ 93:24, 26–28.
3. 1 Самуел 15:22.
4. Сургаал ба Гэрээ 64:34.
5. 1 Нифай 3:7.
6. Эхлэл 22:12.
7. Эхлэл 22:18.
8. Иосеф Ф.Смит, *Дээрэт Ньюс*, Хагас жил тутмын Чуулган, 1873 оны 11-р сарын 12, 644.
9. Гордон Б.Хинкли, “If Ye Be Willing and Obedient,” *Ensign*, 1971 оны 12 сар, 125.
10. Абрахам 3:25.
11. Сургаал ба Гэрээ 132:5.
12. Еврей 5:8–9.
13. Матай 4:1–11-ийг үз.
14. Лук 22:44.
15. Лук 22:42.
16. Иохан 21:22.
17. Сургаал ба Гэрээ 93:28.

Бидэнд зориулсан сургаал

“Бидэнд зориулсан сургаал”-ыг Санваартны анги болон Нийгмийн халамжийн бүлэгт сарын дөрөвдэх бүтэн сайн өдөр заана. Хичээл бүрийг хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээр бэлтгэж болно (доорх хүснэгтийг үз). Гадас болон дүүргийн ерөнхийлөгч нар ашиглах материалаа сонгох буюу бишоп болон салбарын ерөнхийлөгч нарт сонгохыг даалгаж болно. Удирдагч нар, Мелкизедек санваартан ах нар болон Нийгмийн халамжийн бүлгийн эгч нар ням гарагт ижил хичээл үзэхэд анхаарах хэрэгтэй.

Дөрөв дэх ням гарагийн хичээлд ирж буй хүмүүсийг сүүлд гарсан чуулганы сэтгүүлийг авчирч судлахыг урамшуулна.

Хэлсэн үгсээс хичээлд бэлтгэх зөвлөмжүүд

Хичээлийг судалж, заахад Ариун Сүнс тантай хамт байж болохын тулд залбир. Та өөр

материал ашиглан хичээлээ бэлдэхийг хүсч болох ч чуулган дээр хэлсэн үгс нь батлагдсан хөтөлбөр юм. Таны үүрэг бол Сүмийн хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр заагдсан сайн мэдээг сурч, түүний дагуу амьдрахад нь бусдад туслах явдал юм.


Материалаа давтан уншиж, ангийн гишүүдийн хэрэгцээнд тохирох зарчмууд болон сургаалыг эрж хай. Түүнчлэн эдгээр үнэнийг заахад тань туслах түүхүүд, судрын эшлэлүүд болон өгүүлэмжийг хэлсэн үгсээс хай.

Зарчмууд болон сургаалыг яаж заахаа тоймло. Ангийн гишүүдээс туслах асуултуудыг асуу:

- Хэлсэн үгсээс зарчим болон сургаалыг хай.
- Тэдгээрийн утгыг тунгаан бод.
- Ойлголт, санаа бодол, туршлага болон гэрчлэлээ хуваалц.
- Эдгээр зарчмууд болон сургаалыг тэдний амьдралтай холбо.

САР БҮРИЙН ЗААХ ЁСТОЙ ХИЧЭЭЛҮҮД	ДӨРӨВ ДЭХ НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛУУД
2013 оны 4-р сар–2013 оны 10-р сар	2013 оны 4-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгс*
2013 оны 10-р сар–2014 оны 4-р сар	2013 оны 10-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгс*

* 4 болон 10-р сарын дөрөв дэх ням гарагийн хичээлдээ хамгийн сүүлийн ерөнхий чуулган эсвэл өмнөх чуулган дээр хэлсэн үгсээс сонгож болно. Эдгээр хэлсэн үгсийг conference.lds.org хаягаар олон хэлээр унших боломжтой.



Ерөнхийлөгч Хэнри Б.Аиринг
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

“Над уруу ир”

Христэд хэрхэн ойр байж болохыг Тэрээр, Өөрийн үг болон үлгэр жишээгээрээ бидэнд харуулсан байдаг.

Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн энэхүү чуулганд та бүхэнтэй хамт байгаадаа талархалтай байна. Энэ бол Түүний сүм. Бид Түүний хаант улсад орохдоо Түүний нэрийг өөрсөд дээрээ авдаг. Тэр бол Бурхан, Бүтээгч, мөн төгс төгөлдөр билээ. Бид бүгд мөнх бус бөгөөд үхэл болон нүгэлд өртдөг. Гэсэн ч Тэр бидэнд болон гэр бүлүүдэд маань хайртай учраас, биднийг Өөртэйгөө ойр байхыг хүсдэг. Тэрээр ингэж айлджээ: “Надад ойр байгтун, мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн эрэлхийлэгтүн, мөн та нар намайг олох болно; асуу, тэгвэл та нар хүлээн авах болно; тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.”¹ гэсэн юм.

Христийн дахин амилсны энэ баярын үеэр бид яагаад Түүнийг хайрладаг талаар, мөн Өөрийнх нь үнэнч найзууд болно хэмээх итгэлт шавь нартаа өгсөн Түүний амлалтыг бид дурсан санадаг. Хэрэв бид Түүнд үйлчлэх аваас, Тэрээр бидэн рүү ирнэ гэж Аврагч маань амласан. Нэг жишээ нь Оливер Каудэрийг бошиглогч Иосэф Смиттэй хамт Мормоны Номыг орчуулан Их

Эзэнд үйлчилж байхад нь өгөгдсөн илчлэлтэд: “Болгоогтун, чи бол Оливер, чиний хүслийн учир би чамд ярилаа; тиймийн тул эдгээр үгсийг зүрх сэтгэлдээ нөөцөл. Бурханы зарлигуудыг дагахад итгэлтэй хийгээд хичээнгүй байгтун, мөн би чамайг хайрынхаа мутарт тэвэрнэм” хэмээн хэлсэн байдаг.²

Аврагчид илүү ойр очиж, мөн Түүнийг надад илүү ойртон ирэхийн баяр баяслыг би ихэнхдээ тушаалуудад дуулгавартай байх энгийн үйлдлүүдээр дамжуулан мэдэрсэн юм.

Та нар ч мөн үүнийг мэдэрч байсан. Энэ нь магадгүй та ариун ёслолын цуглаанд очихыг сонгосон үе байж болох юм. Миний хувьд, энэ нь намайг бага байхад Хүндэтгэлийн өдөр тохиосон юм. Тухайн үед бид ариун ёслолын цуглаанаа орой хийдэг байлаа. 65 гаруй жилийн өмнө нэг өдөр, намайг гэр бүлийнхэнтэйгээ болон гэгээнтнүүдтэй хамт цугларах тушаалыг дагаж байсан тэр дурсамж минь одоо ч намайг Аврагчтай ойртуулдаг юм.

Гадаа харанхуй бөгөөд хүйтэн байлаа. Тэр үдэш эцэг эхийнхээ

хамт ариун ёслолын танхимд гэрэл мөн дулааныг мэдэрч байснаа би санаж байна. Бид Аароны санваартнуудын адисласан ариун ёслолоос хүртэж, Түүний Хүүг дурсан санаж, мөн Түүний зарлигуудыг дагана хэмээн Тэнгэрлэг Эцэгтэйгээ гэрээ хийсэн.

Цуглааны төгсгөлд бид “Өө Аврагч минь, энэ үдэш надтай хамт үлдээч” хэмээх “Abide with Me; 'Tis Eventide”³ дуулыг дуулсан юм.

Тэр үдэш би Аврагчийн хайрыг мөн Түүнийг ойр байгааг мэдэрч билээ. Түүнчлэн Ариун Сүнс намайг тайтгаруулсан юм.

Өсвөр насандаа ариун ёслолын цуглааны үеэр мэдэрсэн Аврагчийн хайр болон Түүний оршихуйг дахин нэг удаа мэдрэхийг би хүссэн юм. Тиймээс би саяхан нэгэн тушаалыг биелүүлж судруудыг судалсан юм. Ингэснээр, дахин амилсан Их Эзэн шавь нарынхаа гэрт нь ирж, тэдэнтэй байх урилгыг хүлээн зөвшөөрөх үед тэдний мэдэрсэн зүйлийг би ч мөн Ариун Сүнсээр мэдэрч чадна гэдгийг мэдэж байсан.

Би Түүний Цовдлолт болон оршуулгаас 3 өдрийн дараа юу болсныг уншсан юм. Итгэлтэй эмэгтэйчүүд болон тэдэнтэй хамт ирсэн бусад хүмүүс булшны амыг хаасан чулуу нь хөдөлж, Түүний бие байхгүй байгааг мэджээ. Тэд Түүнийг хайрласан учраас биеийг нь тослохоор ирсэн байлаа.

Хоёр тэнгэр элч ирээд тэднийг юунд айсныг асуусан байна:

“Та нар юунд үхэгсдийн дунд амьд Нэгнийг хайна вэ?”

“Тэр энд байхгүй, харин Тэр амилсан. Галилд байхдаа Тэр та

нарт юу айлдаж байсныг санацгаа.

“Хүний Хүү нүгэлт хүмүүсийн гарт тушаагдаж, цовдлоодоод гурав дахь өдөр нь амилах ёстой гэсэн шүү дээ”⁴

Маркийн номонд тэрээр нэг тэнгэр элчийн, зүг заасан хэсгийг нэмсэн байдаг: “Харин явж, Түүний шавь нар болон Петрт “Есүс та нараас өмнө Галил руу явна. Яг л айлдсаных нь дагуу та нар тэнд Түүнийг харах болно.”⁵

Төлөөлөгчид болон шавь нар нь Иерусалимд цуглав. Тэд өөр хоорондоо Түүний үхэл ба дахин амилалт нь тэдний хувьд ямар учиртай болох талаар ярилцаж байхдаа айж, мөн гайхацгааж байлаа.

Тэр үдэш шавь нарын хоёр нь Иерусалимаас Эммау орох замдаа алхаж байлаа. Дахин амилсан Христ тэдний замд гарч ирэн, тэдэнтэй хамт алхав. Их Эзэн тэдэн дээр очжээ.

Лукийн ном биднийг тэр үдэш тэдэнтэй хамт алхах боломжийг олгодог:

“Тэднийг ийнхүү ярьж хэлэлцэн явтал, Есүс Өөрөө тэдний дэргэд ирээд, цугтаа алхав.

Гэвч тэдний нүд халхлагдаж, Түүнийг таньсангүй.

“Есүс тэдэнд—Та нар бие бие-тэйгээ юун тухай ярилцаж яваа юм бэ? гэсэнд, тэд зогсов. Тэд гунигтай байлаа.

“Тэдний нэг Клеоп гэгч нь Түүнд—Энэ өдрүүдэд Иерусалимд болсон явдлын тухай Та л ганцаараа мэдэлгүйгээр энд аялж яваа хэрэг үү?” гэв.⁶

Есүс Израилын Цагаатгагч байх болно гэж хэлсэн боловч Тэр нас барчихсан гээд тэд гунигтай байгаагаар Түүнд хэлсэн байна.

Дахин амилсан Их Эзэн эдгээр харамсаж гашуудсан шавь нартаа хандан ярихад Түүний дуу хоолойнд ямар нэг нөлөө орсон байж таарах нь.

“Есүс тэдэнд хандан,—Мунхаг хүмүүс ээ! Эш үзүүлэгчдийн хэлсэн бүхэнд итгэхдээ хойрго сэтгэлтэн-гүүд ээ!

“Христ энэ бүх зовлонг эдлэн, тэгээд Өөрийн сүр жавхланд орох ёстой байсан биш үү?

“Тэгээд Тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав.”⁷

Тэр үед намайг жаал хүү байхад мэдэрсэн тэр халуун дулаан мэд-рэмж зүрхэнд минь дахин ирлээ:

“Тэд зорьж явсан тосгондоо ойртон ирэх үед Тэр цаашаа явах гэж байгаа мэт байв.

“Тэд Түүнийг ятган, бидэнтэй хамт байгаач: өдөр ч хэдийнээ хэвийж, орой болж байна гэж хэлэхэд нь Есүс тэдэнтэй үддэхээр болж, гэрт оров.”⁸

Тэр шөнө Аврагч Эммау тосгоны ойролцоох шавь нарынхаа гэрт нь орох урилгыг хүлээн авсан юм.

Тэгээд Тэр тэдэнтэй хамт ширээнэ тухлан сууж, талх авч адислан, хуваагаад тэдэнд өгөв. Тэдний нүд нээгдэж, тэд Түүнийг танив. Тэгээд Есүс нүдэнд нь харагдахгүй алга болжээ. Лук бидэнд зориулж тэдгээр адислагдсан шавь нарын сэтгэгдлийг ийнхүү цэдэглэсэн байна: “Тэд нэг нэгэндээ—Замд Тэр бидэнтэй ярилцаж, Судрыг бидэнд тайлбарлаж байхад нь зүрх маань [бидний дотор] шатаж байсан бус уу?”⁹

Тэр даруйдаа хоёр шавь нь тэдэнд юу тохиолдсоныг 11 төлөөлөгчид хэлэхээр Иерусалим руу яаран буцлаа. Яг тэр мөчид Аврагч дахин гарч иржээ.

Есүс Эцгийнхээ бүх хүүхдүүдийн нүглийн төлөө цагаатгал хийж, үхлийн хүлээсийг тайлах номлолынхоо бошиглолуудыг дахин авч үзэв.

“Есүс тэдэнд хандаж —Христ зовлон эдэлж, гурав дахь өдрөө үхэгсдээс амилах болно.

“Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн уучлалын гэмшил тунхаглагдах ёстой” гэж бичигдсэн юм.

“Энэ бүхний гэрч бол та нар мөн.”¹⁰

Аврагчийн тухайн үед шавь нар-таа болон бидэнд хандаж хэлсэн

үгс нь үнэн. Бид энэ бүхний гэрч мөн. Бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэхдээ эрхэм хүндтэй үүргийг хүлээн авсныг бошиглогч Алама олон зууны өмнө Мормоны усны дэргэд тодорхой болгосон юм:

“Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, Мормоны Ус энэ байна (учир нь энэ нь тийн нэрлэгдсэн байв) мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн байв;

“Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, мөнх амьдралыг авч болохын тулд, Бурханаар гэтэлгэгдэж, мөн та нар анхны амилуулалтын тэдний дунд тоологдож болохын тулд буюу—

“Эдүгээ би та нарт хэлнэ, хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юулж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?

Мөн эдүгээ хүмүүс эдгээр үгийг дуулаад, тэд баярласнаас алгаа ташин, мөн ийн хашгирцаав: Энэ бол бидний зүрхний хүслэн билээ.”¹¹

Бид амьд яваа насандаа тусламж хэрэгтэй тэднийг дэмжиж, Аврагчийг гэрчлэх гэрээнд орсон билээ.

Бид зөвхөн Аврагчийн төлөөх хайр болон Түүний биднийг гэсэн хайрыг мэдэрснээр л энэ үүргээ биелүүлэх боломжтой юм. Бид өгсөн амлалтандаа итгэлтэй байснаар, Түүнийг гэсэн хайр маань өсөн нэмэгдэхийг мэдрэх болно. Учир нь Түүнд үйлчлэхдээ бид Түүний хүчийг, мөн Түүнд илүү ойртож байгаагаа мэдрэх болно.

Ерөнхийлөгч Томас С.Монсон Их Эзэний итгэлтэй шавь нартаа өгсөн дараах амлалтыг бидэнд ойр ойрхон сануулдаг: “Мөн та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн, тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтэй байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно.”¹²

Түүнийг бидэнтэй илүү ойр байгааг танд бас надад мэдрүүлсэн өөр нэгэн арга бий. Биднийг Түүнд үнэнчээр үйлчлэхэд, хайртай гэр бүлийн гишүүдэд маань Тэр ойртон ирдэг. Би Их Эзэний үйлчлэлд дуудагдаж гэр бүлээ түр орхих эсвэл нүүх бүрт, Их Эзэн эхнэр хүүхдүүдийг маань адислаж байсныг олж мэддэг юм. Тэр өөрийн хайрт үйлчлэгчдэдээ Өөрт нь илүү ойртон ирэх боломжуудыг бэлдсэн байдаг.

Та бүхэн амьдралдаа үүнтэй адил адислалыг мэдэрч байсан. Та нарын хайртай хүмүүс дунд мөнх амьдралын замаасаа гараад бэ-дэрч яваа нэгэн байгаа. Та тэднийг эргүүлэн авчрахын тулд өөр юу хийж чадахаа мэдэхийг хүсч байгаа. Та Түүнд итгэлтэй үйлчилснээр Их Эзэн тэдгээр хүмүүст илүү ойртон очих болно.

Иосеф Смит, Сидней Ригдон нар гэр бүлээсээ хол сайн мэдээг номлож явах үед Их Эзэн тэдэнд дараах амлалтыг өгснийг та нар санаж байгаа: “Миний найзууд Сидней мөн Иосеф, та нарын гэр бүлүүд сайн байна; тэд миний мутарт буй, мөн би өөрт сайн санагдсаныг тэдэнд үйлдэх болно; учир нь надад бүх хүч буй.”¹³

Алма болон Мозая хааны адил, зарим эцэг эхчүүд Их Эзэнд урт удаан мөн хамгийн сайнаараа үйлчилж, Их Эзэний төлөө хэдий их золиослол хийсэн ч хүүхдүүд нь замаасаа төөрөн одсон нь бий. Тэд өөрсдийн чадах бүхнээ, бүр итгэлтэй, хайраар дүүрэн найз нөхдийнхөө тусламжтайгаар

хүүхдүүдийнхээ төлөө хийж болох бүхнийг хийсэн юм.

Алма бусад гэгээнтнүүдтэй хамт хүүгийнхээ болон Мозая хааны хөвгүүдийн төлөө залбирахад, тэнгэр элч тэдэн дээр ирсэн билээ. Та болон итгэлээ хэрэгжүүлдэг бусад хүмүүсийн залбирал Их Эзэний үйлчлэгчдийг гэр бүлийнхэнд тань туслуулахаар авчирдаг юм. Энэ нь тэднийг Бурханд эргэж очих замыг сонгоход туслах болно. Бүр гэр бүлүүдийг энэ амьдралд болон үүрд мөнхөд устгах зорилготой Сатан ба түүний дагалдагч нар бидний гэр бүлийнхэн рүү дайрсан үед ч гэсэн Их Эзэний үйлчлэгчид тэдэнд маань туслах болно.

Та нар залуу Алма болон Мозая хааны хөвгүүдийн эсэргүүцлийн үед Тэнгэр элчийн тэдэнд хэлсэн дараах үгсийг санаж байгаа: “Мөн түүнчлэн, тэнгэр элч хэлэв: Болгоогтун, Их Эзэн өөрийн хүмүүсийн залбирлуудыг, мөн түүнчлэн өөрийн үйлчлэгч, таны эцэг болох Алмагийн залбирлуудыг сонссон; учир нь та үнэний мэдлэгт авчрагдаж болохын тулд таны талаар их итгэлтэйгээр тэрээр залбирсан бөлгөө; тиймийн тул, энэ зорилгоор түүний үйлчлэгчдийн залбирлууд тэдний итгэлийнх нь дагуу хариулагдаж болохын тулд Бурханы хүч болон эрх мэдлийг танд итгүүлэхийн тулд ирлээ, би.”¹⁴

Их Эзэнд хандан залбирдаг мөн үйлчилдэг та бүхний өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ хүсэх адислал бүхэн ирнэ гэж би амлаагүй. Харин Их Эзэн та нартай илүү ойр байж, танд болон таны гэр бүлийнхэнд хамгийн сайн байх тэр л зүйлээр адислана гэдгийг би амлаж чадна. Та бусдад тусламжийн гараа сунган үйлчилснээр, Түүний хайраас ирдэг тайтгарлыг олж аван, Түүнийг танд илүү ойртон ирэхийг мэдрэх болно. Та тусламж хэрэгтэй тэдний шархыг боож, нүгэлдээ шаналан буй тэдэнд Аврагчийн Цагаатгалын ариуслыг өргөн барьснаар Их Эзэний хүч таныг дэмжих болно. Тэрээр Тэнгэрлэг Эцэгийн

маань хүүхдүүдийг, түүнчлэн танай гэр бүлийнхнийг халамжилж, мөн адислахаар та нартай хамт гараа сунгасан байдаг юм.

Биднийг тэнгэрлэг гэртээ эргэн очиход сүр жавхлантайгаар угтан авах болно. Тэр үед бид хайрт Их Эзэний маань амлалт гүйцэлдсэн байхыг харах болно. Энэ бол Тэнгэрлэг Эцэгтэй хамт мөнх амьдралд биднийг угтан авах Тэр Нэгэн билээ. Есүс Христ үүнийг сударт ингэж хэлжээ:

“Миний Сионыг урагш авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн. Бүх зүйлүүдэд миний зарлигуудыг сахигтун.

“Мөн, хэрэв чи миний зарлигуудыг сахиж мөн эцсээ хүртэл тэвчих аваас, чи Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу бэлэг болох мөнх амьдралтай байх болно.”¹⁵

“Учир нь амьдарч буй тэд дэлхийг өвлөх болно, мөн нас нөгчих тэд бүхий л хөдөлмөрүүдээсээ амрах болно, мөн ажлууд нь тэднийг дагалдах болно; бас тэд өөрсдөд нь зориулсан миний бэлтгэсэн Эцэгийн минь харшуудад титэм хүлээн авах болно.”¹⁶

“Энэ бол Миний Хайртай Хүү, Түүнийг сонс!”¹⁷ хэмээх Тэнгэрлэг Эцэгийн урилгыг бид Сүнсээр дагаж чадна гэдгийг би гэрчилж байна.

Христ Өөрийн үгс болон үлгэр жишээгээр, хэрхэн Түүнд илүү ойр байхыг бидэнд үзүүлсэн билээ. Түүний сүмд баптисмын хаалгаар орохыг сонгосон Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүр Түүний сайн мэдээг заалгаж “Над уруу ирэгтүн”¹⁸ хэмээх Түүний урилгыг үйлчлэгчдээс нь сонсох боломжтой байх болно.

Энэ дэлхий болон сүнсний дэлхий дээр Түүний хаант улсад Түүнтэй гэрээнүүд хийсэн бүх үйлчлэгчид, Түүнд зориулан бусдад үйлчилж, бусдыг адислах үед Түүний зааврыг Сүнсээр дамжуулан хүлээн авах болно. Тэгээд тэд Түүнд илүү ойр байхын баяр баяслыг олж мөн Түүний хайрыг мэдрэх болно.

Би тэр нэгэн үдэш хоёр шавийнх нь Эммау дахь гэрт тэдэнтэй хамт

байсан мэт Их Эзэний дахин амилалтыг баттайгаар гэрчилж байна. Тэр нэгэн сайхан өглөө Иосеф Смит Палмира дахь ойн төгөлд Эцэг, Хүү хоёрыг гэрэлт баганад харахдаа Түүнийг амьд гэж мэдэж авсан шиг Тэр амьд гэдгийг би баттайгаар мэднэ.

Энэ бол Есүс Христийн үнэн сүм. Зөвхөн Ерөнхийлөгч Томас С.Монсоны атгаж буй санваарын түлхүүрүүдэд, бид гэр бүлийнхэнтэйгээ холбогдож, Тэнгэрлэг Эцэг болон Их Эзэн Есүс Христтэй хамт мөнхөд амьдрах хүч байдаг. Бид шүүлтийн өдөр Аврагчийн өмнө нүүр нүүрээ хараад зогсох болно. Тэр өдөр энэ амьдралд Түүнд хийсэн үйлчлэлээрээ Түүнтэй илүү ойртож очсон тэдгээр хүмүүст “Сайн байна, итгэмжит сайн үйлчлэгч

минь” хэмээх үгсийг сонсох баярт мөч байх болно. Би гэрчийн хувиар эдгээр бүгдийг дахин амилсан Аврагч, бидний Гэтэлгэгч Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

ТЭМДЭГЛЭЛҮҮД

1. Сургаал ба Гэрээ 88:63.
2. Сургаал ба Гэрээ 6:20.
3. “Abide with Me; 'Tis Eventide,” *Hymns*, дугаар 165.
4. Лук 24:5–7.
5. Марк 16:7.
6. Лук 24:15–18.
7. Лук 24:25–27.
8. Лук 24:28–29.
9. Лук 24:32.
10. Лук 24:46–48.
11. Мозая 18:8–11.
12. Сургаал ба Гэрээ 84:88.
13. Сургаал ба Гэрээ 100:1.
14. Мозая 27:14.
15. Сургаал ба Гэрээ 14:6–7.
16. Сургаал ба Гэрээ 59:2.
17. Иосеф Смит—Түүх 1:17.
18. Матай 11:28.
19. Матай 25:21.